

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2022/144/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Чингис хот
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390

Аудитор: Б.Ариунаа
Утас: 93032714

Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13
4.1 Залруулсан алдаа.....	13
4.2 Төлбөрийн акт	14
4.3 Албан шаардлага.....	14
4.4 Зөвлөмж.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2022.03.09 № 164

танай _____ -ны № _____ -т

Г Аудитын санал дүгнэлт гаргах тухай Г

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зэрчлийн үр нөлөөг эс тооцвол Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг зөрчин 11,214.4 мянган төгрөгийг зарцуулсан, үндэслэлгүй 24,500.0 мянган төгрөгийн тэтгэмж олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан, ээлжийн амралтын хоног тооцоогүй 2,196.1 мянган төгрөгийн цалин давхардуулан олгож нийт 37,910.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь оршин байх, эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

023030050

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	281,725,052.77	316,397,717.00
33	АВЛАГА	-	9,500,000.00
335	Бусад авлага	-	9,500,000.00
3351	Байгууллагаас авах авлага	-	9,500,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	281,725,052.77	306,897,717.00
351	Түүхий эд материал	8,743,060.00	8,685,980.00
35110	Тусгай зориулалттай материал	6,309,600.00	6,606,100.00
35130	Эм боох материал	2,433,460.00	2,079,880.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	593,500.00	1,209,972.00
354	Хангамжийн материал	271,732,492.77	296,188,765.00
35410	Бичиг хэргийн материал	46,695,705.46	51,120,593.51
35420	Аж ахуйн материал	33,099,558.00	34,025,508.00
35460	Хүнсний материал	1,626,200.00	4,590,150.00
35470	Бусад хангамжийн материал	190,311,029.31	206,452,513.49
35600	Мал амьтад	656,000.00	813,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,481,376,753.43	2,435,095,079.24
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,481,376,753.43	2,435,095,079.24
392	Биет хөрөнгө	1,962,044,753.43	1,915,763,079.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,918,041,133.76	1,918,041,133.76
39202	Хуримтлагдсан элэгдэл	(100,382,662.76)	(151,483,386.80)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	248,944,899.12	246,228,409.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	(198,084,118.68)	(173,692,791.05)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	123,278,561.09	124,245,850.09
39208	Хуримтлагдсан элэгдэл	(55,670,338.40)	(65,371,313.82)
39214	Бусад үндсэн хөрөнгө	34,595,555.67	38,410,555.67
39215	Хуримтлагдсан элэгдэл	(8,678,276.37)	(20,615,378.31)
393	Биет бус хөрөнгө	519,332,000.00	519,332,000.00
39301	Програм хангамж	1,237,798.00	1,237,798.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,237,798.00)	(1,237,798.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	519,332,000.00	519,332,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,763,101,806.20	2,751,492,796.24
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,763,101,806.20	2,751,492,796.24
51	Засгийн газрын хувь оролцоо	2,763,101,806.20	2,751,492,796.24
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	990,622,936.62	990,622,936.62
51101	Өмч: - төрийн	990,622,936.62	990,622,936.62
512	Хуримтлагдсан үр дүн	540,411,784.74	528,802,774.78
51210	Өмнөх үеийн үр дүн	540,411,784.74	540,411,784.74
51220	Тайлант үеийн үр дүн	-	(11,609,009.96)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,232,067,084.84	1,232,067,084.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,763,101,806.20	2,751,492,796.24

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,679,567,602.14	1,488,383,712.09
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	126,194,852.14	55,345,912.09
120	Нийтлэг татварын бус орлого	126,194,852.14	55,345,912.09
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	126,194,852.14	55,345,912.09
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	126,194,852.14	55,345,912.09
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,553,372,750.00	1,433,037,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,341,080,900.00	1,220,060,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,230,439,600.00	1,220,060,000.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	110,641,300.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,294,050.00	39,299,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	8,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,294,050.00	31,299,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	197,997,800.00	173,678,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	197,997,800.00	173,678,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,471,278,916.66	1,499,113,053.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,471,278,916.66	1,499,113,053.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,396,284,192.15	1,404,655,344.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	870,231,235.33	871,569,334.00
210101	Үндсэн цалин	597,516,903.94	557,135,572.00
210102	Нэмэгдэл	195,325,732.39	247,526,732.00
210104	Урамшуулал	77,388,599.00	66,907,030.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	108,802,329.16	113,754,507.33
210201	Тэтгэврийн даатгал	75,337,219.02	79,783,323.77
210202	Тэтгэмжийн даатгал	8,752,087.47	9,212,637.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,542,272.35	6,883,467.05
210204	Ажилгүйдлийн даатгал	1,607,638.78	1,625,007.40
210205	Эрүүл мэндийн даатгал	16,563,111.54	16,250,071.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	189,104,887.00	165,485,380.00
210301	Гэрэл, цахилгаан	10,860,423.00	12,114,483.00
210302	Түлш, халаалт	162,109,488.00	136,073,064.00
210303	Цэвэр, бохир ус	16,134,976.00	17,297,833.00
2104	Хангамж, бараа материалын зардал	57,579,271.15	74,868,839.66
210401	Бичиг хэрэг	11,324,620.00	6,498,815.70
210402	Тээвэр, шатахуун	1,927,000.00	1,850,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	811,200.00	2,190,770.00
210404	Ном, хэвлэл	1,132,794.00	3,018,128.76
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,013,900.00	816,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	41,369,757.15	60,495,125.20
2105	Нормативт зардал	18,107,392.00	30,339,672.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,480,842.00	5,303,372.00
210502	Хоол, хүнс	12,139,600.00	20,464,050.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,486,950.00	4,572,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,196,590.00	19,202,050.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	685,000.00	-
210604	Урсгал засвар	26,511,590.00	19,202,050.00
2107	Томиллолт, зочны зардал	962,000.00	1,000,000.00
210702	Дотоод албан томиллолт	962,000.00	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,054,300.00	3,952,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,334,300.00	1,936,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	2,016,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	111,246,187.51	124,483,161.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,404,000.00	3,577,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,749,273.81	25,679,914.10
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	97,092,913.70	95,225,347.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	74,994,724.51	94,457,708.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,042,950.00	71,945,636.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,429,950.00	45,548,486.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,613,000.00	26,397,150.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	49,951,774.51	450,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	49,951,774.51	450,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	492,620.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	492,620.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	21,569,452.67
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	21,569,452.67
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	208,288,685.48	(10,729,341.35)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	879,668.61
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	879,668.61
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(879,668.61)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	208,288,685.48	(11,609,009.96)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,553,372,750.00	1,433,037,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,553,372,750.00	1,433,037,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,341,080,900.00	1,220,060,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,230,439,600.00	1,220,060,000.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	110,641,300.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,294,050.00	39,299,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	8,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,294,050.00	31,299,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	197,997,800.00	173,678,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	197,997,800.00	173,678,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,442,731,450.00	1,409,872,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,442,731,450.00	1,409,872,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,368,429,475.49	1,313,607,539.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	870,234,569.33	871,569,333.00
210101	Үндсэн цалин	597,520,237.94	557,135,571.00
210102	Нэмэгдэл	195,325,732.39	247,526,732.00
210104	Урамшуулал	77,388,599.00	66,907,030.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	108,802,329.16	113,754,508.33
210201	Тэтгэврийн даатгал	75,337,219.02	79,783,324.77
210202	Тэтгэмжийн даатгал	8,752,087.47	9,212,637.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,542,272.35	6,883,467.05
210204	Ажилгүйдлийн даатгал	1,607,638.78	1,625,007.40
210205	Эрүүл мэндийн даатгал	16,563,111.54	16,250,071.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	189,104,887.00	165,485,380.00
210301	Гэрэл, цахилгаан	10,860,423.00	12,114,483.00
210302	Түлш, халаалт	162,109,488.00	136,073,064.00
210303	Цэвэр, бохир ус	16,134,976.00	17,297,833.00
2104	Хангамж, бараа материалын зардал	63,419,867.00	66,093,118.00
210401	Бичиг хэрэг	5,398,820.00	2,822,700.00
210402	Тээвэр, шатахуун	1,456,000.00	1,850,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	811,200.00	2,190,770.00
210404	Ном, хэвлэл	413,231.00	2,410,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,013,900.00	816,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	54,326,716.00	56,002,848.00
2105	Нормативт зардал	23,323,155.00	31,473,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,212,505.00	2,584,800.00
210502	Хоол, хүнс	9,897,250.00	24,000,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,213,400.00	4,888,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	48,781,500.00	8,750,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,663,400.00	150,000.00
210602	Тавилга	14,999,000.00	-
210604	Урсгал засвар	8,119,100.00	8,600,000.00
2107	Томиллолт, зочны зардал	962,000.00	1,000,000.00
210702	Дотоод албан томиллолт	962,000.00	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,994,300.00	25,906,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,274,300.00	23,890,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	2,016,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,806,868.00	29,575,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,340,500.00	5,164,100.00
210902	Жичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	42,466,368.00	24,411,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	74,301,974.51	96,265,260.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,350,200.00	73,753,188.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,450,200.00	45,471,358.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,900,000.00	28,281,830.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	49,951,774.51	450,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	49,951,774.51	450,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	492,620.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	492,620.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	21,569,452.67
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	21,569,452.67
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	110,641,300.00	23,165,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	23,385,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	23,385,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	23,385,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	19,350,000.00
223001	Бусад хөрөнгө	-	4,035,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(23,385,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	110,641,300.00	(220,000.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	990,622,936.62	1,232,067,084.84	540,411,784.74		2,763,101,806.20
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	990,622,936.62	1,232,067,084.84	540,411,784.74	-	2,763,101,806.20
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	990,622,936.62	1,232,067,084.84	540,411,784.74		- 2,763,101,806.20
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	990,622,936.62	1,232,067,084.84	540,411,784.74		- 2,763,101,806.20
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	990,622,936.62	1,232,067,084.84	540,411,784.74	-	2,763,101,806.20
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(11,609,009.96)		(11,609,009.96)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	990,622,936.62	1,232,067,084.84	528,802,774.78		- 2,751,492,796.24

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,393,738,000.00	1,371,675,927.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,393,738,000.00	1,371,675,927.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,326,507,600.00	1,304,938,239.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	879,012,300.00	871,569,333.00
210101	Үндсэн цалин	564,463,100.00	557,135,571.00
210102	Нэмэгдэл	245,126,200.00	247,526,732.00
210104	Урамшуулал	69423000.00	66907030.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	125,142,200.00	113,754,508.33
210201	Тэтгэврийн даатгал	87,127,800.00	79,783,324.77
210202	Тэтгэмжийн даатгал	9,503,600.00	9,212,637.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,602,900.00	6,883,467.05
210204	Ажилгүйдлийн даатгал	1,900,700.00	1,625,007.40
210205	Эрүүл мэндийн даатгал	19,007,200.00	16,250,071.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	165,973,600.00	165,485,380.00
210301	Гэрэл, цахилгаан	12,500,000.00	12,114,483.00
210302	Түлш, халаалт	136,073,600.00	136,073,064.00
210303	Цэвэр, бохир ус	17400000.00	17297833.00
2104	Хангамж, бараа материалын зардал	50,902,000.00	50,772,718.00
210401	Бичиг хэрэг	2,072,700.00	2,072,700.00
210402	Тээвэр, шатахуун	900,000.00	900,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,191,200.00	2,190,770.00
210404	Ном, хэвлэл	1,432,800.00	1,432,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	816,000.00	816,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	43,489,300.00	43,360,448.00
2105	Нормативт зардал	32,989,600.00	30,872,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,015,400.00	1,984,400.00
210502	Хоол, хүнс	26,083,900.00	24,000,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,890,300.00	4,888,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,204,400.00	27,200,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,500,000.00	19,500,000.00
210604	Урсгал засвар	7,704,400.00	7,700,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.00	1,000,000.00
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,166,000.00	24,166,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,150,000.00	22,150,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,016,000.00	2,016,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,117,500.00	20,117,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,635,000.00	1,635,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,482,500.00	18,482,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,230,400.00	66,737,688.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	67,230,400.00	66,737,688.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	38,730,400.00	38,455,858.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,500,000.00	28,281,830.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,393,738,000.00	1,371,675,927.33
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,220,060,000.00	1,198,490,547.33
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,220,060,000.00	1,198,490,547.33
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	173,678,000.00	173,185,380.00
132001	Орон нутгийн төсвөөс	173,678,000.00	173,185,380.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	39,299,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	39,299,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,834,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,135,400.00
210401	Бичиг хэрэг	750,000.00
210402	Тээвэр, шатахуун	950,000.00
210404	Ном, хэвлэл	978,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,457,400.00
2105	Нормативт зардал	600,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	600,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	900,000.00
210604	Урсгал засвар	900,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,740,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,740,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,458,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,529,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,929,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,465,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,015,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,015,500.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	450,000.00
213303	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	450,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	39,299,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	39,299,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	31,299,800.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Ариунаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт нь танхимын сургалт удаан хугацаагаар зогссоны улмаас хүүхдийн дунд үүсэж болзошгүй түгшүүр, хөгжлийн ялгаатай байдал, сурлагаар хоцрох, сургууль завсардах зэрэг эрсдэлээс сэргийлэх хариу арга хэмжээ авч, тэгш бус байдлыг бууруулах ажлыг хэрэгжүүлэх үр дүнг тооцох, гэнэтийн буюу давтагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтын үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангаж, сургалтыг танхимын болон танхимын бус хосолсон хэлбэрээр хүүхдийн сурах үйл, оролцоог дэмжин тэгш хүртээмжтэй чанартай зохион байгуулахад оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас тус байгууллагын 2019, 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,471.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 22.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 14.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11.6 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	9.5	(9.5)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	281.7	306.9	(25.2)
Үндсэн хөрөнгө	2,481.4	2,435.1	46.3
Нийт хөрөнгө	2,763.1	2,751.5	11.6
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо	2,763.1	2,751.5	11.6
Засгийн газрын оролцоо /Өмч-Төрийн/	990.6	990.6	-
Өмнөх үеийн үр дүн	540.4	540.4	-
Тайлант үеийн үр дүн	-	(11.6)	11.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,232.1	1,232.1	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,763.1	2,751.5	11.6

Авлага 9.5 сая төгрөгөөр өссөн нь сургуулийн өргөтгөлийн барилгын зураг төсвийн үнийг төлсөнтэй холбоотой үүсжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 25.2 сая төгрөгөөр өсөж, үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 46.3 сая төгрөгөөр буурсан. Энэ нь үндсэн хөрөнгөөс тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил актлагдсантай холбоотой байна

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,751.5 сая төгрөг болж, 11.6 сая төгрөгийн тайлант оны үр дүнгээр буурсан.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 93.6 сая төгрөгөөр буюу 7.6 хувиар өссөн нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт нь орон нутгийн төсвийн санхүүжилт байна.

Нийт зардал өмнөх оноос 7.8 сая төгрөгөөр буюу 0.6 хувиар буурсан нь тогтмол зардалтай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 1,728.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 334.7 сая төгрөгөөр бууруулан 1,393.7 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг тусгай зориулалтын шилжүүлгээс 1,220.0 сая төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 173.7 сая төгрөгөөр нийт 1,393.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 1,220.0 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 173.7 сая төгрөг нийт 1,393.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,371.7 сая төгрөг зарцуулж, 21.5 сая төгрөгийг улсын төсөвт, 0.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 8.0 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 31.3 сая төгрөг нийт 39.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 28.8 сая төгрөг зарцуулж, 0.5 сая төгрөг орон нутгийн төсөв төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцлох асуудал байхгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Аудитаар илэрсэн гол асуудал байхгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны нэгдсэн системд байршуулсан мэдээллийг шалгахад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтыг таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээллийг 56.2 сая төгрөгөөр дутуу мэдээлсэн.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар зөвлөмж өгөгдөөгүй, түрээсийн орлогын төвлөрүүлээгүй 0.4 сая төгрөгт төлбөрийн акт тогтоогдсон нь бүрэн барагдсан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар бараа материалын тооллого, тооцоо бодолт, анхан шатны баримтын бүрдүүлэлт, хөрөнгийн зарцуулалт бодитой хийгддэг эсэх, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүг үндсэн хөрөнгө тус бүрээр авч үзэх болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 113.8 сая төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 9.7 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 2.2 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 45.7 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 56.2 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Бараа материалын дэлгэрэнгүй тайлангаар орлого, зарлага 0.2 сая төгрөгөөр зөрүүтэй байсныг залруулав.

Сургуулийн өргөтгөлийн барилгын зураг төсөвт шилжүүлсэн 9.5 сая төгрөгийг зардалд бүртгэснийг залруулж авлагаар тусгав.

4.2 Төлбөрийн акт

Ээлжийн амралтын хоногийн тооцоо хийгээгүйгээс 2.2 сая төгрөгийн цалин давхардуулан олгосон.

4.3 Албан шаардлага

Батлагдсан төсвөөс үндэслэлгүйгээр 24.5 сая төгрөгийн тэтгэмж олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан.

Батлагдсан төсвийн 10-аас доошгүй хувийг хэмнэх арга хэмжээ аваагүйгээс 6.3 сая төгрөг хэмнээгүй, 3.7 сая төгрөгөөр тавилга, ширээ сандал худалдан авсан.

Батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг зөрчин бага үнэтэй түргэн элэгдэх зүйлээс 11.2 сая төгрөгийн засварын материал, хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэсэн.

4.4 Зөвлөмж

4.4.1 Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 56.2 сая төгрөгийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн системд мэдээлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны нэгдсэн системд мэдээлбэл зохих мэдээллийг хууль тогтоомжид заасан хугацаанд, бүрэн мэдээлж байх.

Зөвлөмжийн биелэлтийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 5 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Хэнтий аймгийн Хэрлэн сумын 2-р сургууль	5	47.6	2	9.7	1	2.2	2	35.7		
ДҮН		5	47.6	2	9.7	1	2.2	2	35.7		
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Хэнтий аймгийн Хэрлэн сумын 2-р сургууль	2	66.2					1	10.0	1	56.2
ДҮН		2	66.2					1	10.0	1	56.2
НИЙТ ДҮН		7	113.8	2	9.7	1	2.2	3	45.7	1	56.2



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 11/АДЗ70448
ХЭА-2022/144/НА СТА ТШС

Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Хэрлэн сумын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ээлжийн амралтын хоногийн тооцоог хийгээгүйгээс 2,196.1 мянган төгрөгийн цалинг давхардуулан олгосон байна.

Энэ нь ЭМ, НХС-ын 2000 оны хамтарсан тушаалаар батлагдсан "ээлжийн амралт олгох заавар"-ын 13-т "Ажил олгогч нь ажилтанг ажлаас халагдахаас бусад тохиолдолд болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол биеэр эдлээгүй ээлжийн амралтын оронд мөнгөн олговор олгож болохгүй." гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Давхардуулан олгосон 2,196.1 мянган төгрөгийн цалинг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хэрлэн сумын 2 дугаар сургуулийн захирал К.Түмэндэлгэр, нягтлан бодогч Д.Эрдэнэтуяа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.АРИУНАА

Д.ОЮУНТУЯА

231714297



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 09

Дугаар 95/А2370448
ХЭА - 2022/144/НА -ЭТА -ТНД

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг зөрчин бага үнэтэй түргэн элэгдэх зүйлээс 11,214.4 мянган төгрөгийн засварын материал, хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэсэн.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн захирал К.Түмэндэлгэр, нягтлан бодогч Д.Эрдэнэтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.АРИУНАА

Д.ОЮУНТУЯА





ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 09

Дугаар 96/А2370448
ХЭА - 2022/144/НА - СТН - ТЦЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн сумын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсвөөс үндэслэлгүйгээр 24,500.0 мянган төгрөгийн тэтгэмж олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах" гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн захирал К.Түмэндэлгэр, нягтлан бодогч Д.Эрдэнэтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР



Б.АРИУНАА

Д.ОЮУНТУЯА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 09

Дугаар 97/АДЗ70448

Чингис хот

ХЭА - 2022/144/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсвийн 10-аас доошгүй хувийг хэмнэх арга хэмжээ аваагүйгээс 6,332.5 мянган төгрөг хэмнээгүй, 3,704.0 мянган төгрөгөөр тавилга, ширээ сандал худалдан авсан.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1 дугаар зүйлийн 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах", 1.4-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх," гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 2-р сургуулийн захирал К.Түмэндэлгэр, нягтлан бодогч Д.Эрдэнэтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

Б.АРИУНАА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА



623041423